


Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх



# Мөнхийн гэр бүлийн хайрын найдвар

**Б**идний хайрт Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдээ бэлдсэн бүх бэлгээс хамгийн агуу нь мөнх амьдрал юм (С ба Г 14:7-г үзнэ үү). Тэрхүү бэлэг бол Бурхан Эцэгийн болон Түүний Хайрт Хүүгийн дэргэд гэр бүлтэйгээ хамт амьдрах явдал билээ. Зөвхөн Бурханы хаант улсуудын хамгийн дээд нь болох селестиел хаант улсад л гэр бүлийн хайрын холбоо үргэлжлэх боломжтой.

Бид хайраар дүүрэн гэр бүлд амьдрах баяр баясалд найддаг. Бидний заримд энэ бол мэдэрч үзээгүй буюу боломжтой гэдгийг нь мэддэг ч хараахан хүлээн аваагүй тэрхүү мэдрэмж юм. Бид үүнийг бусдын амьдралаас харсан ч байж болно. Бусдад маань хүүхэд, аав, ээж, ах, эгч эсвэл хайрт эмээ, өвөөгөөсөө хагацах тэр мөчид гэр бүлийн хайр илүү бодитой, үнэ цэнтэй санагддаг.

Бид ихэд хайрладаг байсан гэр бүлийнхээ гишүүний халуун дулаан хайрыг хэзээ нэгэн цагт дахин мэдэрнэ, түүнийгээ дахин тэвэрнэ гэсэн найдварыг мэдэрч байсан биз ээ.

Хайрт Тэнгэрлэг Эцэг маань бидний зүрхний хүсэл эрмэлзлийг мэднэ. Түүний зорилго бол бидэнд аз жаргалыг өгөх явдал юм (2 Нифай 2:25-ыг үзнэ үү). Тиймээс Тэрээр мөнхөд үргэлжлэх гэр бүлийн холбооны баяр баясгаланг боломжтой болгохын тулд Өөрийн Хүүг бэлэг болгон өгсөн. Аврагч үхлийн хүлээсийг тайлсан учраас бид амилуулагдах болно. Тэр бидний нүглийг цагаатгасан учраас бид итгэл, наманчлалаар дамжуулан гэр бүлүүд хайранд үүрд хамт байх селестиел хаант улсад орохуйц зохистой болж чадна.

Аврагч санваарын түлхүүрүүдийг сэргээхээр бошиглогч Елиаг Иосеф Смит рүү илгээсэн (С ба Г 110-ыг үзнэ үү). Тэдгээр түлхүүрийн хамт лацдан холбох хүч ирсэн бөгөөд Бурханы хүүхдүүдээ өгөх хамгийн агуу бэлэг болох гэр бүлүүд үүрд хамт байх мөнх амьдралыг боломжтой болгосон билээ.

Энэ бол дэлхийд ирсэн Бурханы хүүхэд бүрд өгөгдсөн боломж юм. Түүний сүнсэн хүүхдүүдийн гуравны нэг нь сүнсний дэлхийд байхдаа энэхүү боломжоос татгалзсан. Тэд хангалттай итгэлтэй байгаагүйгээс эсэргүүцэж, Тэнгэрлэг Эцэгийн мөнхийн гэр бүлийн бэлгээс ирэх баяр баяслыг хэзээ ч мэдрэхгүй байхыг сонгосон.

Мөнх бус байдлын өмнөх сүнсний дэлхий дээрх уг хүнд сорилтыг давсан бид мөнх бус бие махбодын бэлгийг хүлээн авах бөгөөд мөнх амьдрал хүлээн авах сонголтыг ч хийж чадна. Хэрэв бид сэргээгдсэн сайн мэдээг олох боломжоор адислагдсан юм бол биднийг мөнх амьдралд орохуйц болгох гэрээг Бурхантай хийж, сахихыг сонгож болно. Биднийг итгэлтэй байж, тэвчих үед Ариун Сүнс селестиел хаант улсад гэр бүлтэйгээ үүрд хамт амьдрах мөнх амьдралын зам дээр байгаа гэсэн итгэл, найдварыг маань бататгах болно.

Зарим хүн уг үүрдийн баяр баяслыг хүлээн авах найдварыг мэдрэхгүй байж болох юм. Эцэг эх, хүүхдүүд, ах эгч нар нь мөнх амьдралд ороход зохисгүй болгох сонголтуудыг хийсэн байж болно. Та Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан мөнх амьдралд зохистой болсон гэдэгтээ эргэлзэж байж ч болох юм.

Бурханы бошиглогч нэг удаа надад амар амгаланг мэдрүүлсэн зөвлөгөөг өгч билээ. Бусдын сонголт манай гэр бүлийн үүрд хамт байх боломжийг үгүй хийж магадгүй хэмээн би санаа зовж байв. Тэрээр “Та буруу асуудалд санаагаа зовоож байна. Та зүгээр л селестиел хаант улсад орохуйц зохистой амьдар. Харин гэр бүлийн зохион байгуулалт нь таны төсөөлж байгаагаас ч гайхалтайгаар хийгдэх болно” гэж хэлсэн.

Тэнгэрлэг Эцэг сүнсэн хүүхдүүдийнхээ хувьд таныг мэддэг бөгөөд танд хайртай гэдгийг хувийн болон гэр бүл, үр хүүхдүүдийн асуудлаас эсвэл хань ижил, үр хүүхэдгүй байгаагаасаа болж мөнх амьдралын найдварыг орхисон хүмүүст би гэрчилж байна. Энэ амьдралаас өмнө Түүнтэй болон Түүний Хайрт Хүүтэй хамт байхад Тэд таны зүрх сэтгэлд мөнх амьдралын найдварыг суулгасан юм. Есүс Христийн Цагаатгалын хүч ажиллаж, Ариун Сүнс удирдаж байгаа цагт Эцэгийн болон Түүний Хайрт Хүүгийн таныг хүлээн аваасай гэж хүсдэг тэрхүү гэр бүлийн хайрыг та одоо болон ирэх дэлхийд мэдэрч чадна.

Та селестиел хаант улсад орохуйц зохистой амьдарвал “гэр бүлийн зохион байгуулалт нь таны төсөөлж байгаагаас ч гайхалтайгаар хийгдэх болно” гэсэн бошиглолын амлалт таных байх болно гэдгийг би гэрчилж байна.

## ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Хичээлээ эхлэхдээ мөнхийн гэр бүлтэй байх найдварт талархаж байсан үеийнхээ тухай зааж буй хүмүүстээ ярихад анхаар. Тэднийг мөнхийн гэр бүлтэй байх боломжтой байгаадаа талархаж байсан үеэ тунгаан бодоход урь. Хуваалцмаар байгаа эсэхийг нь тэднээс асуу. Та тэднийг “гэр бүлийн зохион байгуулалт нь таны төсөөлж байгаагаас ч гайхалтайгаар хийгдэх болно” гэсэн бошиглолын амлалтыг хүлээн авахын тулд селестиел хаант улсад орохуйц зохистой амьдрах, өсөж хөгжих арга замуудын талаар бодоход урьж болно.

## ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

### Үүрдийн аз жаргалыг хамтдаа эдлэх нь

Сайн мэдээний хамгийн агуу зүйлсийн нэг бол авралын төлөвлөгөөний талаарх мэдлэг юм. Бидэнд

гэр бүлтэйгээ үүрд хамт байх гайхалтай боломж бий. Энэ мэдлэг нь бидэнд дэлхий ертөнцийн асуудалд дарагдан гутрах үедээ найдвар тээхэд тусалдаг. Ерөнхийлөгч Айринг “Хайрт Тэнгэрлэг Эцэг бидний зүрхний хүсэл эрмэлзлийг мэднэ. Түүний зорилго бол бидэнд аз жаргалыг өгөх явдал юм (2 Нифай 2:25-ыг үзнэ үү). Тиймээс Тэрээр мөнхөд үргэлжлэх гэр бүлийн холбооны баяр баясгаланг боломжтой болгохын тулд Өөрийн Хүүг бэлэг болгон өгсөн. . . . Энэ бол дэлхий дээр ирсэн Бурханы хүүхэд бүрд өгөгдсөн боломж юм” хэмээн заасан.

Энэ адислал нь одоо амьдарч байгаа бидэнд өгөгддөг төдийгүй биднээр дамжуулан нас барсан хүмүүст өгөгддөг. Өвөг дээдэс маань сүнсний дэлхийд байгаа бөгөөд тэдний өмнөөс ариун сүмийн ёслолуудыг хийхэд нэрс бэлдэхийг биднээс хүлээж байгаа. Гэвч заримдаа тэдний өмнөөс уг ажлыг хийхэд хэцүү байдаг. Бид хэт завгүй эсвэл ариун сүмд тогтмол ороход дэндүү хол байж болно.

Аз болоход гэр бүлийн түүхийн ажил, индексжүүлэлт эсвэл эцэг эх нь ариун сүм рүү явсан үед дүү нараа харах зэрэг өвөг дээдэстээ туслах бусад арга зам байдаг. Ингэж тусалснаар бид Их Эзэнд үйлчилдэг ба сүнсний дэлхийд байгаа хүмүүст мөнхийн гэр бүлийн найдварыг авчирдаг.

## ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

### Гэр бүлүүд үүрд мөнх

Есүс Христийн Цагаатгал, санваарын түлхүүрүүдийн сэргээлт байгаа учраас бид гэр бүлтэйгээ үүрд хамт амьдарч чадна! Чи гэр бүлийнхээ юунд дуртай вэ? Гэр бүлээ хөгжөөхийн тулд дараах зааврыг дагаж, цаасан хэлхээ хий.

1. Цаасыг голоор нь нугалж, нэг урт тууз үүсгэ.
2. Нугалсан ирмэгт гар нь хүрч байхаар хүн зур.
3. Зурсан хүнээ хайчил. Нугалсан ирмэгт хүрч буй гарын хэсгийг хайчлалгүй үлдээ.
4. Дэлгэ. Гэр бүлийн гишүүн бүрийн чинь юу чамд таалагддаг талаар бичиж эсвэл зур.
5. Хэрэв илүү өнөр гэр бүлтэй бол хэд хэдэн хэлхээг хооронд нь нааж холбож болно!



## Гэр бүлээ хамтдаа халамжлах нь

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийг эрэлхийл. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг ойлгох нь хэрхэн таны Бурханд итгэх итгэлийг нэмэгдүүлэн, айлчлагч багшийн хувьд харж ханддаг хүмүүсийн тань амьдралыг адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол [reliefsociety.lds.org](http://reliefsociety.lds.org) хаягаар орж үзнэ үү.

Итгэл, гэр бүл, халамж

“Эхнэр, нөхөр хоёр нь бие биеэ болон үр хүүхдээ хайрлан халамжлах хариуцлага хүлээнэ.”<sup>1</sup> Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон “Гэр орон бол Бурханы хайр, үйлчлэлийн лаборатори юм” хэмээн хэлсэн.

“Тэнгэрлэг Эцэг эхнэр, нөхрүүдээс бие биедээ үнэнч байж, хүүхдүүдээ Их Эзэний өв хэмээн хүндлэн харьцахыг хүсдэг.”<sup>2</sup>

Мормоны Номонд эхнэрээ хайрлах нөхрийн хайр, нөхрөө хайрлах эхнэрийн хайр болон хүүхдүүдээ хайрлах тэдний хайр леменчүүдийг нифайчуудаас илүү зөв зохистой болгож байсан нэгэн шалтгаан байсан талаар Иаков хэлдэг (Иаков 3:7-г үзнэ үү).

Гэртээ хайр, эв нэгдэл авчрах хамгийн сайн аргуудын нэг бол гэр бүлийнхээ гишүүдтэй эелдэг харьцах явдал юм. Эелдэг харьцах нь Ариун Сүнсний авчирдаг. Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Линда К.Бертон эгч: “Бид бие биедээ сайхан

үгсийг чин сэтгэлээсээ хэр ойр ойрхон хэлдэг вэ?” гэсэн асуултын талаар эргэцүүлэн бодохыг биднээс хүссэн.<sup>3</sup>

### Нэмэлт судрууд

Ром 12:10; Мозая 4:15;  
Сургаал ба Гэрээ 25:5

### Бодит түүх

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон хайраар дүүрэн гэр бүлийн ач холбогдлыг өөрт нь заасан хүүхэд насныхаа нэгэн туршлагыг хуваалцсан. Түүнийг болон ах нарыг нь бага байхад, ээж нь хорт хавдрын хагалгаанд орсон бөгөөд баруун гар нь хөдлөхөд хүндрэлтэй байв. Олон хүүтэй учраас маш олон хувцас индүүдэх хэрэгтэй байдаг байлаа. Гэвч ээж нь тэдгээрийг индүүдэхдээ заримдаа унтлагын өрөөндөө орж, өвчнөө намдтал уйлдаг байжээ.

Ахлагч Кристоффэрсоны аав үүнийг мэдмэгцээ, бараг нэг жилийн турш нууцаар өдрийн

цайгаа уулгүй мөнгө хэмнэж, эхнэртээ индүүдэх төхөөрөмж худалдаж авсан байна. Тэрээр эхнэрээ хайрлах хайраараа гэр бүлээ халамжлахын жишээг хөвгүүддээ үзүүлсэн юм. Сайхан сэтгэлийн энэхүү жишээний талаар ахлагч Кристоффэрсон: “Ээжид үзүүлдэг байсан аавын хайрын үйлдэл, золиослолыг би тэр үед анзаараагүй ч, одоо мэдэж байна. ‘Тэр бол жинхэнэ агуу хүн’ гэж би өөртөө хэлдэг”<sup>4</sup> хэмээн өгүүлжээ.

### ЭШЛЭЛҮҮД

1. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” *Liahona*, 2010 оны 11-р сар, 129.
2. Рассэлл М.Нэлсон, “Salvation and Exaltation,” *Liahona*, 2008 оны 5-р сар, 8.
3. Линда К.Бертон, “Хамтдаа өсөж хөгжицгөө,” 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 31.
4. Д.Тодд Кристоффэрсон, “Let Us Be Men,” *Ensign* эсвэл *Liahona*, 2006 оны 11-р сар, 46

### Үүнийг эргэцүүлэн бод

Бие биенээ хайрлаж,  
халамжлах нь Сүнснийг гэрт  
хэрхэн урьдаг вэ?